



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.01.12, ПҮРЭВ ~ №008 (554)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхий сайд халаагуур, шөнийн тоолуурыг зээлээр авах боломжийг бүрдүүлэхээ амлав.
Засгийн газрын хуралдаанаар 15 сумын эмнэлэгт УАЗ маркийн машин өгөхөөр боллоо.
УИХ-ын дарга авлигын хэргээр шийтгүүлсэн хүнд төр дахин итгэл үзүүлэхгүй гэлээ.
АН-ын даргын сонгуульд өрсөлдөгч тав Говь-Алтай аймгийнхантай уулзжээ.
Үндсэн хуулийн ойлголт тэмдэглэж, Б.Чимидийн нэрэмжит шагнал олгоно.

ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк 118 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 14 хувийн хүүтэйгээр арилжаалав.
Монголын хөрөнгийн биржийн индекс 848.63 нэгж болж 0.18 хувиар өсөв.
Санхүүгийн салбарын хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд санал авна.
Төмрийн хүдрийн ханш мянгар гарагаас хойш 5.5 хувиар өсөв.
АНУ-ын жижиг, дунд бизнесийн орчин зэрэг хүлээлттэй байна.

НИЙГЭМ

Батлан хамгаалахын салбар авлигад өртөх өндөр эрсдэлтэй гэж дүгнэжээ.
900 гаруй бөхөнгийн сэг зэмийг устгаж, ариутгал, халваргүйжилт хийсэн байна.
"Өргөө" амаржихын төрөх өрөөний тааз нурсан хэргээр барилгын компанийг шүүхэд өгчээ.
Өнгөрсөн жил олдсон археологийн олдворуудаар өнөөдөр үзэсгэлэн гаргахаар болов.
СХД-ийн 26 дугаар хорооны иргэдийн хүсэлтээр нийтийн тээврийн 426 чиглэл нээлээ.

ДЭЛХИЙ

Кремль Трампын эсрэг баримт цуглуулж буй тухай мэдээллийг WikiLeaks үгүйсгэлээ.
Пан Ги Муны төрөл төрөгсдийг АНУ авлигын хэрэгт буруутгалаа.
Япон цаг агаараас болж сансар руу мини пуужин хөөрөх туршилтаа хойшуулав.
Жорж Лукас Лос Анжелест "Оддын дайн"-ы музей байгуулна.
БНХАУ-д Pokemon Go тоглоомыг түр хориглов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.01.12



-16° | -25°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРХҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС ҮНШИНЭ ҮҮ.



Бүхэрх хуулиар хамгаалагдана ©

Сар шинэдээ бэлдэх таатай үе



Өнгөрсөн онд ууцны үнэ 250 мянган төгрөг байсан бол энэ жил даруй 100 мянгаар хямдарчээ. Гэвч Цагаан сарын баярын өдрүүдэд үнэ өсөх магадлалтай. ▶7

С.Батсайхан / ЗГМ

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Тал зассан нөхөөстэй төсөл

Б.Тулгат
ЗГМ

Төрөлжсөн банкны үйл ажиллагааг зохицуулах хуулийн төслийг УИХ-ын даргад он солигдохын өмнө УИХ-ын нэр бүхий зарим гишүүд хамтран өргөн мэдүүлсэн. Энэ нь Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл. Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Б.Жавхлан гишүүнээр ахлуулсан МАН-ын 20 гаруй гишүүн уг хуулийн төслийг боловсруулсан юм. Хуулийн төсөлдтэй зэрэгцээд БНХАУ-ын Үйлдвэр худалдааны банкинд Монгол Улсад төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрлийг Монголбанкнаас олгов.

Дэлхийн шилдэг банкуудын жагсаалтыг гурван жил дараалан тэргүүлж буй 42 улсад 400 гаруй салбар нэгжтэй олон улс дамнасан банкны салбар төлөөлөгчийн газраа нээхээр болж байна. Хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээр зорьж байгаа нь сайшаалтай. Гэвч дээрх хуулийн төсөлд ноцтой алдаа, дутагдал их байгаа зарим эдийн засагч хөндөж байна. Тэдний үзэж буйгаар таван бүлэг, 18 зүйлтэй Хөрөнгө оруулалтын банкны хуулийн төслийг илүү чамбайруулах шаардлагатай аж.

Манай улсын хувьд төв болон арилжааны банкны хоёр хуультай. Харин дээрх хуулийн төсөл нь банкны системийн гурав дахь цоо шинэ хууль болох юм.

▶3

ЗГМ: ИНФОГРАФИК

ШАР АЙРАГ БА КОФЕГ ХЭРЭГЛЭХ ТОХИРОМЖТОЙ ҮЕ



ХҮРТЭХҮЙ АДЕНОЗИН



Зохицуулагч аденозин хүний биед орсноор ажигламтгай болдог.

Харин 15 минутын дараа кофейн үйлчилж эхэлснээр эрч хүч нэмэгддэг.

УУХ ТОХИРОМЖТОЙ ҮЕ

Шинэ содон санааны эрэлд гарсан бол шар айраг тохиромжтой. Олсон санаагаа сайжруулж, төвлөрөх шаардлагатай бол кофе сонгоорой. Гэвч хэтрүүлвэл хор болно.

ДҮГНЭЛТ

Шинэ санаа
Гүйцэтгэл

dailyinfographic.com

УЛС ТӨР

Улаанбаатар тахлын голомт болсныг анхаарууллаа

Б.Гандолгор
@gandolgorZGM

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр сэтгүүлдчидтэй "Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай" сэдэвт зангиагүй уулзалт хийлээ. Тэрбээр уулзалтын эхэнд агаарын бохирдлыг бууруулахад хэвлэл мэдээллийнхний оролцоо тааруу байна хэмээн нэлээд эмлэнгүй хэлээ. Тэрбээр "Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан нийслэлийн агаар, орчны бохирдлын асуудлыг хэлэлцлээ. Тус хурлаар зөвлөмж гаргасан. Үндсэн хуульд байдаг гол заалт нь Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Мөн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй. Тэгэхэд Улаанбаатар хотын орчин

аюултай болчихоод байна.

Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах нь Үндсэн хуулийн дагуу авсан арга хэмжээ. Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гэж бий. Үүнийг ч гэсэн үндэслэж шийдвэр гаргасан. Эхийн хэвлийд бүрэлдэж буй хүүхэд амьгүй болох хэмжээнд хүрсэн гамшигийг аюул гэхгүй өөр юу гэх юм бэ. Үүнд төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа нийцүүлэхгүй бол өөр юунд нийцүүлэх вэ. Иргэд амьжиргаагаа залгуулах гэж л хотод нүүж ирсэн. Түүнээс эрүүл мэндээрээ хохирох гэж хот бараадаагүй. 2009 онд анх Ерөнхийлөгч болохдоо Улаанбаатар гамшигийн хот болсныг хэлж байсан.

▶2



Shanghai Tower - Хятадын бэлгэ тэмдэг

FINANCIAL TIMES

Габриэль Вилдау

Шанхайн тэнгэр баганасан барилга ирээдүйн бэлгэ тэмдэг болсоор бага бус хугацаа өнгөрчээ. Итгэхгүй бол хиймэл оюун ухаан, цаг хугацаагаар зорчих аялал, нарийн технологийн тагнан турших ажиллагааны тухай киноны ерөнхий зураглалд тус хотыг ашигладаг Холливудын найруулагч нараас асуугаад үзэгтүн.

Спайк Жонзийн "Нег" кинонд Шанхайг футурист стиль бүхий ирээдүйн Лос Анжелес хотын дүрд хувиргасан. Скарлет Йоханссоны дуу оруулсан

компьютер үйлдлийн системд дурлаж буй гол дүрийн (жүжигчин Хоакин Феникс) хайрын түүхийг уг кинонд өгүүлдэг. "Looper" кинонд цаг хугацаагаар хэсүүчлэгч, хөлсний алуурчин Брюс Уиллис 2074 он хүртэл 30 жил амьдрахаар Шанхайд ирдэг. Түүнийг алахаар өөрийнх нь залуу цагийн хувилбар араас нь ирнэ. "Mission Impossible III"-т Том Круз биоэвсэг хулгайлаад 88 давхар Jinmao Tower-ээс олсоор буудаг хэсэг бий.

▶9

MSE ALL

848.63
0.18%

АЛТ

1188.30
0.08%

ЗЭС

5758
2.99%

10-ЧИНГИС БОНД

85.789
0.01%

5-ЧИНГИС БОНД

96.750
0.03%

АМ.ДОЛЛАР

2497.66

ЮАНЬ

360.57

РУБЛЬ

41.53

Нийтлэлчийн булан

Тал зассан нөхөөстэй төсөл

Бүдэрч мэдэх төсөл буюу Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль



Б.Ганбаяр / ЗГМ

Тиймээс хуулийн төслийг сайтар боловсруулах нь ирээдүйд үүсч мэдэх хүндрэл, эрсдэлийг хаана гэсэн үг. Гадаадын банк Монголд үйл ажиллагаа эрхлэх эрхийг нээх хуулийн төслийг санаачилсан зарим гишүүн банк, санхүүгийн салбарын хөгжлийг хурдасгах онцгой ач холбогдолтойг тэмдэглэж буй. Үүнтэй зарим судлаач санал нэгдэхгүй байгаа юм. Учир нь санхүүгийн салбараа эрсдэлд оруулна хэмээн тайлбарлаж байна. Хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулахад тавигдах шаардлагуудыг харахад нэг банк хуулийн төсөлд тусгасан шаардлагыг маш сайн хангах аж.

Тодруулбал, гадаадын хөрөнгө оруулалттай банк салбар нээх зөвшөөрөл авахын тулд нэгээс доошгүй жил төлөөлөгчийн газар байгуулж үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг тавьсан. Үүнийг хангаж буй банкуудын нэг нь "Bank of China" болж байна. Монголбанкинд салбар нээх хүсэлтэй илэрхийлсэн цорын ганц банк бол "Bank of China". Тоймлон хэлбэл, Хятадын банкнаас өөр манай улсад банк байгуулах сонирхолтой улс орон, гадаадын компани байхгүй. Төв банкны албан мэдээллээр манай улсад гадаадын таван банкны төлөөлөгчийн газар байгаагаас хоёр нь урд хөршийнх аж.

Гаднын бусад банк одоогоор

үйл ажиллагаагаа заавал банк үүсгэн байгуулахгүйгээр төлөөлөгчийн газраа байгуулж, гэрээ, хэлцлийн шугамаар зээл олгож буй. Тухайлбал, Европын хөрөнгө оруулалтын банк говийн салхин станцын төсөлд санхүүжилт олгож байгаа юм. Энэ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк байгуулахгүйгээр шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах хууль, эрх зүйн орчин нээлттэй илтгэнэ. Гэтэл зөвхөн нэг банкинд зориулсан хууль гаргаж, бусад гаднын хөрөнгө оруулагчдын оролцоог хааж болохгүй гэсэн шүүмжлэл гараад байна.

Хөрөнгө оруулалтын банкныг үүсгэн байгуулахад тавигдах шаардлагыг зохицуулснаас үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлагыг төсөлд оруулаагүй байгаа зарим судлаач дурджээ. Тодруулбал, хуулийн төсөлд

Төслийн шаардлагыг зөвхөн "Bank of China" хангаж байна

хөрөнгө оруулалтын банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн оруулаагүй нь учир дутагдалтай. Өөрөөр хэлбэл, арилжааны банктай ижил, эсвэл өөр байх уу гэсэн асуулт, хариулт нэхэж байгаа юм.

Гаднын хөрөнгө оруулалтын банкинд хяналт тавихад Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо, төрийн бусад байгууллагууд тэдэнтэй харилцах, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд наад захын болов-

сон хүчний асуудал хүндээр тавигдах нь. Ойлгомжгүй зүйл хуулийн төсөлд цөөнгүй байна.

Хуулийн төслийг УИХ-аас баталвал "Bank of China" салбараа нээнэ гэсэн үг. Уг төслийг Хятадын "Bank of China"-д зориулсан гэж зарим судлаач хардах аж. Хуулийн төсөлд гадаадын төрийн, арилжааны гэсэн зааг ялгааг тусгаагүй байна. Энэ нь олон хүнд "сэжиг" төрүүлэх нь. Банкны тухай хуульд зээл, зээлтэй адилтгах актив хөрөнгийн нийт дүн нь өөрийн хөрөнгийнх нь 20 хувиас хэтэрч болохгүй гэж зохицуулсан байдаг. Харин энэ төсөлд өөрийн хөрөнгийг 20 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс хязгаарлалт тавьжээ. Төсөлд яагаад 20 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс тооцохоор болсон нь тодорхой бус байна.

Анхаарал татаж буй хуулийн

төслийг түүнтэй уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бусад дагалдах хуульд дөрөвхөн хуулийн төслийг хамт өргөн барьжээ. Гэтэл хөрөнгө оруулалтын банк байгуулах, тусгай зөвшөөрөл олгоход Улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг орхигдуулсан байна. Энэ нь хуулийн төсөл тааруу болсныг гэрчлэх алдаа гэж цөөнгүй эдийн засагч үзэж байгаа юм. Ердийн компани байгуулахад болон тусгай зөвшөөрөл авахад улсын тэмдэгтийн хураамж төлөг агал гаднын банк Монгол Улсад Хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулж, тусгай зөвшөөрөл авахад тэмдэгтийн хураамж төлөхгүй байгаа нь ойлгомжгүй үлджээ. Үүнтэй гурван эдийн засагч тутмын хоёр нь санал нийлэхгүй бөгөөд төсөлд нэмж оруулах ёстой гэж үзэж байна.

Банк гэхээр зөвхөн данс нээдэг, хадгаламж байршуулдаг, зээл олгодог байгууллага гэж ойлгодог үе ард хоцорчээ. Хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудад банкны үйл ажиллагааг өргөтгөхийн сацуу арилжааны банк болон Хөрөнгө оруулалтын банкны салбарыг ялан зааглаж байна. Ингэснээр тус бүрт нь тавигдах шаардлага, хууль эрх зүйн зохицуулалтыг тогтоож буй. Уг нь Хөрөнгө оруулалтын банк нь эдийн засгийн баялаг бүтээх томоохон төслүүдэд урт хугацааны санхүүжилт хийж, үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүнийг бий болгох зэргээр арилжааны банктай харьцуулахад илүү өргөн цар хүрээтэй санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг. Энэ жишгээр ажиллаж чадах, эсэх нь үйл ажиллагааг нь дэглэх хуулийн төслөөс эхлэх юм. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ
2017 ОНЫ I УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ.
ЗАХИАЛГЫН ҮНЭ: 21,000₮

УЛИРАЛД

44 ДУГААР



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, И-мэйл: info@zasag.co
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: ubinfo.mn

ЗГМ: Сурвалжлага

Махны үнэ харьцангуй хямд байна

Г.Сайнзаяа
@sainzayaZGM

Цагаан сарын баярын ширээний ууцны махны үнэ ханш, эрэлт нийлүүлэлтийн байр байдлыг Улаанбаатар хотын мах ханган нийлүүлэх томоохон төвүүдээс сурвалжиллаа. Цагаан сар хүртэл 50 орчим хоног дутуу байгаа тул хүмүүс махаа базааж эхлээгүйг “Нарантуул-2” болон “Хархорин” худалдааны төвийнхөн хэлсэн юм. Тэндхийн байдал намгүм. Ихэнх контейнер хаалттай байсан ч машиныхаа ачаан дээр ууц эгнүүлж өрсөн худалдаачин олон байв. Ажлын өдөр болоод тэр үү гэтэл бас үгүй. Хүмүүсийн худалдан авах

орчим ууц л зарагдаж байна. Эдийн засагтай ч бага сага холбоотой байж мэдэх юм, гэхдээ монголчууд үндэсний баяраа өргөн тэмдэглэдэг болохоор сар шинэ дөхөөд эрэлт ихсэх байх. Ажлыг тулгаж хийдэг хүмүүс шүү дээ” гэлээ.

Харин Б.Жаргал “Цагаан сар оройтож байгаа болохоор хэд хоногийн өмнөөс л ууц зарж эхэллээ. Энэ сарын сүүлээр эрэлт ихсэх байх. Одоо бол худалдан авагч мэр сэр л байна даа. Өнгөрсөн жил Цагаан сар эхлэхээс 15 хоногийн өмнө гэхэд л жигдэрчихсэн. Эдийн засгийн нөлөө ч байгаа болов уу. Өглөө ирсэн мах өдөртөө дуусдаг байсан бол одоо хоёр, гурав хоног өнжиж байж л дуусдаг” хэмээн нөхцөл байдлаа тайлбарласан.

Дашрамд сонирхуулахад, “Нарантуул-2” худалдааны төв сар шинийн баярыг тохиолдуулан мах, цагаан идээ

Махны үнэ хямд байгаа энэ үеийг та алдалгүй ашиглавал хожоотой наймаа болох нь.



С.Батсайхан/ЗГМ©

Сар шинэдээ бэлдэх таатай үе

чадвар тэдэнд мэдэгдэхүйцээр буурчээ.

Монголчууд Цагаан сарыг улам өргөн дэлгэр, баялаг тэмдэглэх болсоор буй. Очих айл, идэх бууз, солих хувцасны тоо олширсоор байна. Зарим нь хувцас хунараа одооноос захиалж байгаа бол хэсэг нь буузны махаа базааж эхэлжээ. Махны бөөний төвүүдэд хонины гулууз мах нэг кг нь 3800 төгрөгийн ханштай байгаа аж. Гэвч хүмүүс том хонь авч хүчрэхгүй болсныг худалдаачид яриу.

Л.Ган-Эрдэнэ “Нарантуул-2” дээр мах борлуулаад гурван жил боллоо. Энэ жил хүмүүс мах бага авч байна. Гэхдээ өнгөрсөн онд Цагаан сар эрт болсныг хэлэх үү, шинэ жилийн дараа л ууц гарчихсан. Одоо өдөртөө хоёр

тэргүүтний үзэсгэлэн худалдааг зохион байгуулах юм байна.

Тус төвийн зохион байгуулагч Б.Халиунаа “Иргэдийн худалдан авалт нэлээд буурсан. Энэ жил хөдөө, орон нутагт малын халдварт өвчин хэд хэдэн удаа гарч, улмаар пост дээр ирэх малын тоо ч багассан. Үүнийг дагаад хяналт, шалгалт ч чангарлаа. Ерөнхийдөө нийлүүлэлт, эрэлт ч бага байгаа гэсэн үг. Нэгдүгээр сарын нийт борлуулалт одоогийн байдлаар тааруу гэж дүгнэнэ. Ирэх сард сайжрах байх” гэв.

“Хархорин” худалдааны төвд байдал арай өөр. Худалдан авалт хийж байгаа нь харагдахгүй ч холхих хүн олонтой юм. Уг нь бол “Хүчит Шонхор”, “Нарантуул-2”, “Хархорин” худалдааны төвийн махны

үнэ адилхан ч үйлчлүүлэгч харьцангуй өөр, өөр байлаа. Гэхдээ л нэг худалдаачны бараан дээр тав арваар овоорч, хэл амыг нь сугалах шахам байдаг баярын завгүй өдрийн уур амьсгал алга. Эгнүүлж өрсөн хонины ууц, дээр дээрээс нь давхарласан гулуузны дундуур явахад наймаачид “Хэдэн кг мах авах уу, энийг хар, тэрийг ав” гэж бараагаа сурталчилна. Зарим нэг нь машиныхаа ачаан дээр тохойлдож хэвтчихээд “Өмсөөд үзээрэй, размер байгаа шүү” гэдэг шиг “Үзээд авараай, сонголт байна” гээд байж байх.

Мах гулуузаар нь авах хүн тун ховор байгааг дээр дурдсан. Зарим худалдаачин “Уржигдар буулгасан махаа одоог хүртэл зарж чадаагүй” гэсээр сууж байхтай ч таарлаа. Цагаан сар

бол малчдын хувьд малаа зарж, орлого олох оргил үе. Өнгөрсөн зун махны үнэ унасан тул одоо л хэдэн төгрөг олох юмсан гэж бодоод ирсэн хүн олон байв.

Худалдан авах чадвар мэдэгдэхүйц буурсан

“Бичин жилийн Цагаан сараар 20 ууцтай ирээд 4-5 хоногт зарчихсан. Одоо долоо хоноод ч сураг алга” гэсээр тарган ууцныхаа сүүлний үсийг хайчлах зуураа малчин эр өгүүлсэн юм.

Харин гэгээлэг хэсэг нь өнгөрсөн жилээс муудсан ч,

сайжирсан ч юм алга, баяр дөхөөгүй болохоор ууц авахгүй байна, тулгаж байгаад л базаадаг гэсэн тайлбартай. “Хархорин”-д ч тэр, “Нарантуул-2”-г ч тэр махны үнэ тогтоогоод өгчихсөн юм уу гэлтэй ижил үнэтэй байх аж. 2015 онд ууц 120-250 мянган төгрөг байсан бол энэ жил дунджаар 110-150 орчимд хэлбэлзэж, үнэтэй нь 200 мянгатай. Аваад ирсэн хэдэн малаа мөнгө болгоод буцахыг хэн хүнгүй л хүснэ. Тиймээс ч зарим нь баяр дөхөж, эрэлт ихсэх үеэр бусад худалдаачнаас нууцаар хямдхан борлуулах бодолтой гэнэ. Харин үхрийн өвчүү нэг кг нь 6000, үхрийн мах дээд тал нь 4500 төгрөг байгаа юм. Харин ямааны мах нэг кг нь 2000-2500 төгрөг. Цагаан сар дөхөөд махны үнэ нэмэгдэхийг

таарсан худалдаачин бүр хэлж, зарим нэг нь энэ хавар махны үнэ өснө хэмээн таамаглалаа. Өнгөрсөн жилийн мөн үед хонины нэг кг мах дунджаар 4520, үхрийн ястай мах 6015, үхрийн цул мах 7565, ямааны ястай мах 3575 төгрөгийн үнэтэй байв. 2016 онд Цагаан сарын шинийн 1-н хоёрдугаар сарын 9-нд тохиосон. Тэгэхээр уг үнэ бол баяр дагаж хөөрөгдсөн байх магадлалтайг тодотгох хэрэгтэй.

Ямартай ч одоогийн байдлаар махны үнэ урьд, урьдынхтай харьцуулахад тун боломжийн байгаа тул амжиж авахыг зөвлөж байна. Эртэч шувуухай хоёр өдрийн хоолтой гэдэг шиг, замын түгжрэлгүй, махны үнэ хямд байгаа энэ үеийг та алдалгүй ашиглавал хожоотой наймаа болох нь. [ЗГМ]



Шилдэг САНАА

Bloomberg TV MONGOLIA

Орчин үеийн урлагийн ертөнц урьд урьдынхаасаа хурцаар гэрэлтэж, цэцэглэн хөгжиж байна. XXI зууны шинэ давалгаа, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн салбар болжээ. “Шилдэг санаа” нэвтрүүлгээр энэ хөгжлийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзаж, ярилцан, дэлхий ертөнцийг цоо шинээр нээх болно. Энэ удаагийн дугаарт хувь хүний онцлог чанар, байгаль, улс төр зэрэг өргөн хүрээний сэдвүүдээр бүтээл туурвидаг Майкл Жүг танилцуулах болно.

Пүрэв гараг /2017.01.12/

20:30

11:30 Баасан гараг /давталт/

Амралтын өдрүүдэд

FLSMIDTH VACANCY ANNOUNCEMENT

FLSmidth is a global engineering company supplying one source plants, systems and services to the cement and mineral industries. We supplies large equipment and complete cement and mineral plants, including process and design services, installation, construction supervision, after sales technical site services, and field support to operating sites.

Opportunity:
We are looking for Translator/Driver work at the site. The primary purpose of this role to coordinate, transport and execute all requests for translation of project documentation.

Main accountabilities:
-Translate project documents in written from English to Mongolian and vice versa
-Supports to project experts/expats and provides oral translation into both languages to technical advisors, project visitors and project personnel during meetings, workshops, field visits and research activities
-Assist in taking meeting minutes
-Coordinates expat's transportation, accommodation and their visa issues in accordance with the relevant procedure
-Transports passengers, visitors and packages between UB and Site safely
-Ensures vehicle is being regularly checked and cleaned to ensure it is always ready for use

Qualifications:
-Degree of Bachelor or Master in relevant field, preferable in engineering
-Excellent written and spoken English and Mongolian
-Minimum of consecutive 2 years of experience in translation or interpretation work
-Work experience at mining site.
-Good computer skills with working knowledge of MS Outlook, MS Word, and MS Excel with knowledge of MS Power Point.
-Possess good interpersonal and communication skills
-Ability to work in a multicultural environment

Competence
• Strong Communication and ethic skills
• Good interacting and presenting skills
• High learning agility
• Good time management, self-motivation and other required competences

Please send your CV, copies of diplomas, references and other required documents to sansartuya.tsogbadrakh@flsmidth.com. Deadline for submission of application: January 13, 2017

[ЗАСГИЙН ГАЗРЫН МӨГӨӨ СОНИН] НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ДИЗАЙНЕР:

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Мэргэжлийн чиглэлээр их дээд сургууль төгссөн
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Photoshop, Corel Draw, InDesign, Illustrator болон бусад мэргэжлийн программууд дээр ажиллах чадвартай
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй

ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД:

- Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч
- Хариуцлагатай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Ажлын ачаалал даах чадвартай
- Хувийн зохион байгуулалт, цагийн менежмент сайтай

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүсэгчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхний хуулбар
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын хугацаанд авахуулсан байх)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Өргөдлийг “Засгийн газрын мэдээ сонин”-ны байранд ирж бөглөх болон baasan.b@zasag.co н-мэйл хаягаар явуулна уу. Утас: 7010-3131

Спорт

ТЭТГЭЛЭГ Тэтгэлэгт хөтөлбөр зарлалаа

Г.Оюунтөгс
ЗГМ

Энэ оны санхүүгийн жилд хэрэгжих япон хэл, японы соёлын чиглэлээр суралцаж буй оюутнуудад зориулсан Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр зарлалаа. Бүртгэл энэ сарын 23-27-нд болно. Харин шалгалтыг ирэх сарын 17-нд товложээ. Уг тэтгэлэгт хамрагдсанаар нэг жилийн хугацаанд суралцах бөгөөд сар бүр 117 иений тэтгэлэг авах юм байна. Тус тэтгэлэгт хамрагдахыг хүсвэл доорх материалыг бүрдүүлээрэй.

-Сургуулийн тодорхойлолт (Элсэн он болон одоо хэд дүгээр курст суралцаж буйг тэмдэглэсэн байх)

-Дүнгийн тодорхойлолт

-Иргэний үнэмлэх (эх хувийг үзээд буцааж өгнө)

-Сүүлийн зургаан сарын дотор авахуулсан, 3x4 хэмжээтэй цээж зураг хоёр хувь. [ЗГМ]

ХЭРЭГЛЭЭ

Гялгар утнаас татгалзана



Канад сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Гялгар утнаас татгалзах өдөр" төслийг өнгөрсөн оны аравдугаар сард эхлүүлсэн. Тэгвэл уг төслийн хүрээнд нийслэл хотын хэмжээнд "Гялгар утнаас татгалзах өдөр"-тэй болохоор болжээ. Энэ төслийг дэмжиж Нийслэлийн удирдлагууд ажлын хэсэг байгуулахаар болсон байна. Мөн гялгар уутыг орлох даавуун торны үйлдвэрлэлийг Дэлхийн зөн байгуулагатай хамтран 50 гаруй иргэний оролцоотойгоор эхлүүлсэн аж. Тороо томоохон сүлжээ дэлгүүрүүдтэй гэрээгээр борлуулах юм. Энэ ажлыг дэмжиж байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалж ногоон хөгжилд бодитой хувь нэмэр оруулахыг уриаллаа. [ЗГМ]

НИЙТИЙН ТЭЭВЭР

Автобусны чиглэл нэмэгдэв



Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хороонд хүрдэг нийтийн тээврийн шинэ чиглэлтэй боллоо. Тус хорооны Алтан овооны хэсэгт оршин суудаг иргэдийн хүсэлтээр Нийтийн тээврийн газраас Ч62 чиглэлийн маршрутыг гаргалаа. НИТХ-ын дарга Ц.Сандуйгийн санаачилгаар нийтийн тээврийн үйлчилгээ хүрдэггүй зарим газарт ийнхүү шинэ чиглэлийг нээж байгаа аж. Алтан Овоо-Саппоро Х хороолол чиглэлд өчигдөр нийтийн тээврийн дунд оврын есөн автобус үйлчилгээнд гарч эхлэв. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	07:10 "Монголын шинэ өглөө" хөтөлбөр	07:30 "Студио 1.0" нэвтрүүлэг	07:05 "Математикийн Зарчмууд" хүүхэддэйн кино	09:30 "Тог тог" хүүхдийн нэвтрүүлэг
12.00	10:35 "Хүрээлэн" амьд ертөнцийн цуврал	11:30 "Алсын хараа" нэвтрүүлэг	09:00 "Cook Club" хоолны нэвтрүүлэг	12:00 "Хөтөч" мэдээллийн хөтөлбөр
14.00	14:00 Энд гарц байна	15:00 "Бизнесийн төв цэг" хөтөлбөр	13:20 "Англи хэлний" алсын зайн сургалт	15:00 "Өөрчлөлт" нэвтрүүлэг
18.00	19:25 Эх өв: "Эсгий ширдэг"	20:30 "Шилдэг санаа" нэвтрүүлэг	15:50 "Аугаа уран зургууд" нэвтрүүлэг	19:00 "Спортын шинжлэх ухаан" нэвтрүүлэг
20.00	21:05 Цаг үе, үзэл бодол	22:00 "Японыг судалцаж" нэвтрүүлэг	20:50 "Ялалт" ток шоу нэвтрүүлэг	22:10 "Америкчууд" ОАК
22.00	22:05 "Өглөө" Монголын уран сайхны кино	22:30 "Удирдагчид Лакуатай хамт" нэвтрүүлэг	01:00 "Монголчууд ХХ зууны эхэнд" нэвтрүүлэг	00:50 "Үер" МУСК

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Чөлөөт хос"



Италийн алдарт зохиолч Нобелийн шагналт Дарио Фогийн "Чөлөөт хос" мюзикл, инээдмийн жүжгийг энэ сарын 27, 28-нд Улсын драмын эрдмийн театрт МУУГЗ Ч.Найдандоржийн найруулгаар тоглоно. Энэхүү жүжигт Антония гэх бүсгүй нөхрийнхөө эх захгүй янаг амрагийн явдлаас залхаж амиа хорлохыг завддаг тухай өгүүлнэ. Харин өөрийн чөлөөт амьдралыг илүүд үзсэн нөхөр нь түүнийг элдвээр тайтгаруулж ядаад эцэстээ "чөлөөт хос"-ын амьдралыг санал болгоно. Ингээд эхнэр нөхрийн хооронд өрнөх үйл явдлууд ар араасаа хөвөрнө. Эцэстээ эр нөхөр нь эхнэрээ хардан харамлаж, хайр сэтгэлтэй гэдгээ мянга хэлээд ч тусыг эс олно. Бур амиа хорлохоор оролддог боловч бүх зүйл оройтсон байдаг. Жүжигт гарах эхнэрийн дүрд Ц.Баясгалан, нөхрийн дүрд Э.Тодгэрэл нар тоглох юм. [ЗГМ]

ҮЗВЭР

UB ART GALLERY

"Зэрэгцээ" ертөнц гэрэл зургийн үзэсгэлэн өчигдөр нээлтээ хийлээ. Тус үзэсгэлэн нь нийгэмд болж буй асуудлуудыг хөндсөн аж. Үзэсгэлэн энэ сарын 17-ныг дуустал 10-19 цаг хүртэл үргэлжлэх гэнэ.

МИШЭЭЛ ЭКСПО

"Цагаан сар 2017" үзэсгэлэн худалдаа 50 хүртэлх хувийн хямдрал, урамшуулал зарлаж байна. Энэ сарын 13-16-нд болох сүү, цагаан идээ, тавгийн боов, эвээн, чихэр, жимс, бууз, банш, мах, махан бүтээгдэхүүн, цар, аяга, таваг, ном, бэлэг дурсгал, үндэсний хувцас гээд олон нэр төрлийн барааг үйлдвэрийн үнээр борлуулах юм.

МОНГОЛЫН УРЧУУДЫН ЭМЛЭЛ

Зураач М.Амартүвшингийн "My Journey in Europe" бие даасан үзэсгэлэн энэ сарын 14-нийг хүртэл үргэлжилнэ.

УДБЭТ

Б.Шаравын "Чингис хаан" дуурийг энэ сарын 21-нд үзээрэй. Дуурийн цомнолыг зохиолч П.Бадарч бичсэн бөгөөд Чингис хааны 1171-1189 он хүртэлх амьдралыг өгүүлжээ.

СҮХБААТАРЫН ТАЛБАЙ

Агаарын бохирдлыг бууруулахыг шаардсан жагсаал энэ сарын 28-нд болно. Жагсаалыг "Утааны эсрэг ээж, аав нарын холбоо"-ноос зохион байгуулна.

SPREE CLUB

"Nine Treasures" буюу "Есөн эрдэнэ" хамтлаг энэ сарын 14-ний 19.00 цагт тоглох гэж байна. Тэд "Noise Production"-аас зохион байгуулах металл урсгалын тоглолтуудын салхийг хагалах аж.

КИНО

Адал явдал, тулаант "Return of Xander Cage" кино энэ сарын 20-нд "Өргөө" кино театрт нээлтээ хийнэ.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 15

Өвлийн дунд цагаан хулгана сарын найман цагаан мэнгэтэй, шарагчин гахай өдөр.

Үс засуулбал: Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх: 08.30-17.25
Барилдлага: Хотол
Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй

Аргын тооллын нэгдүгээр сарын 12. Бархасвадь гараг. Билгийн тооллын 15. Өглөг охин одтой, шарагчин гахай өдөр.

Өдрийн наран 08.30 цагт мандаж, 17.25 цагт жаргана. Тухайн өдөр туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сөвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.


ГАЛТ ТЭЭРГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Эрээн	20:00	10:25
УБ-Бээжин	07:15	14:04
Эрхүү-УБ	15:35	06:20
УБ-Эрхүү	21:10	02:40
Замын-Үүд-УБ	17:35	08:55
УБ-Замын-Үүд	17:20	07:05

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	15:30	17:35
Бээжин-УБ	11:55	14:30
УБ-Сөүл	17:10	21:15
Сөүл-УБ	13:00	15:50
УБ-Хонг Конг	07:51	12:25
Хонг Конг-УБ	13:25	18:05

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

- Ханын цаас
- Дэлхийн ноён оргил
- Эверестэд хамгийн анх хөл тавьсан Түвдийн уулчин
- Олууул
- Хөгжмийн нот
- Биеийн төлөөний үг


8. Бэлгэ тэмдэг
9. Орос чихэр
11. Шарсан төмс
12. Ярьдаг шувуу
13. Хүйс
14. Яс хоорондын хөдөлгөөн бүхий холбоос
4. Оскарын шагналд нэр дэвшсэн Монголын киноны нэр "... охин"
7. Шуудангаар явуулсан зүйл
10. Өзлүн эхийн асарч хүмүүжүүлсэн хүү
15. Улс орны хууль тогтоох дээд байгууллага

ХӨНДЛӨНГӨӨР:




ЦАГ АГААР

УЛААНБААТАР	1.12 -16° 7 м/с -25° 5 м/с	1.13 -17° 6 м/с -27° 5 м/с	1.14 -16° 5 м/с -25° 4 м/с	1.15 -17° 6 м/с -24° 4 м/с	1.16 -19° 6 м/с -26° 5 м/с
	Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Үүлшинэ



ЗГМ: КОМИКС



Трампа хүргэнээ ахлах зөвлөгчөөр томилов

36 настай Трампын хүргэн Ойрх Дорнод, худалдааны асуудлаар Ерөнхийлөгчид нөлөөлөх гол хүн болж байна. > 10

Биотехнологийн салбарын сулхан эхлэл

Америкийн биотехнологийн хувьцаа 2017 оныг бүрхэг төлөвөөр уртлаа. > 10

Саудын Араб Исламын бонд гаргана

Тус улс төсвийн алдагдлаа нөхөхийн тулд дэлхийн зах зээлд Исламын бонд худалдахаар эзэхэж байна. > 10

Shanghai Tower - Хятадын бэлгэ ТЭМДЭГ

Хожим 2015 онд 127 давхар Shanghai Tower ашиглалтад ормогц Шанхай хот шинэ футурист бэлгэ тэмдэгтэй боллоо. Нийт 632 метр өндөр уг барилга нь өндрийн үзүүлэлтээрээ Дубайн 828 метр Burj Khalifa-гийн дараа буюу дэлхийд хоёрдугаарт ордог. Цамхагийн зураг төслийг боловсруулсан АНУ-ын Gensler компани барилгын ажлын явцыг баримтжуулахаар гэрэл зурагчин Ноа Шелдоныг хөлсөлжээ. Үйлчлүүлэгчийнхээ захиалгад нийцүүлэн барилгын ажлын зураг авсан ноён Шелдон сайтад нэвтрэх эрхээ ашиглан өөр бусад түүхэн дүрсийг ч гэрэл зурагт үлдээсэн юм.

Сүүлийн 35 жилд хийж гүйцэтгэсэн Хятадын барилгын бүхий л том төслийн нэгэн адилаар Shanghai Tower-ийг ч жижиг хотууд, хөдөөнөөс ирсэн цагаан ажилчдын хүч хөдөлмөрөөр босгосон. Шелдоны гэрэл зургуудад асар өндөрт аюултай ажил хийж буй ажилчдын бахархал, эр зориг үлдэж хоцорчээ. “Барилгын шат угсардаг бригадын ажилчид гэхэд л бүгд Хонань мужийн жижигхэн хотоос ирсэн хүмүүс байх жишээтэй. Бүгд хоорондоо хамаатан садан, анд нөхөд” хэмээн Шелдон тайлбарласан юм. “Хүмүүс ажлаараа бахархахыг

харах нь бидэнд ч сайхан байлаа. Барилгын зурагтай адилаар бидний ажиллаж байгааг ч гэрэл зурагт үлдээгээрэй хэмээн ажилчид гуйдагсан” хэмээн зурагчин дурсан өгүүлэв. Ялангуяа эрчүүдээс ихэнх тохиолдолд огт үл дутах хүнд ажил хийж буй бүсгүйчүүдийг харах нь түүнд почирдом үзэгдэл байлаа. “Эмэгтэйчүүд даан ч хүчир ажил хийнэ. Эрчүүдийн үүрдэг бүхнийг эмэгтэйчүүд ч дутахгүй үүрээд л зүтгэнэ” хэмээн ноён Шелдон ярьсан юм.

Shanghai Tower байрлаж буй Лужязуэй санхүүгийн төв нь Дэн Сяопин 1978 онд эдийн засгийн маонист төлөвлөлтийг арчин хаяснаас хойших Хятад орны шилжилтийн бэлгэ тэмдэг. Энэ газарт 1980-аад оны сүүлч хүртэл агуулах, үйлдвэр, орон сууцны намхан тагз дүүрэн байсан юм. Хожим байдал хурдан өөрчлөгдлөө. Дэлхийн нийт өргөгч цамхагийн 18 хувь нь Шанхайд ажиллаж байгаа талаар тус хотын захирагч 1996 онд тайлбарлаж байв. Өнөөдөр Лужязуэй нь тэнгэр баганадсан өндөр барилгуудыг нягт шахаж барьсан газар болон хувирчээ.

Аз туршигч хоёр орос 2014 онд дуусаагүй барилгын сайтад сэм нэвтэрч, хамгаалах хэрэгсэлгүйгээр дээвэр дээгүүр явж буй бичлэг интернэтэд

2015 онд 127 давхар Shanghai Tower ашиглалтад ормогц Шанхай хот шинэ футурист бэлгэ тэмдэгтэй боллоо.

тавигдсанаар Shanghai Tower дэлхийд алдаршсан. Уг хэргээс болж Шелдоны зураг авах ажилд ч бэрхшээл үүсчээ. Баримт бичиг ном ёсоор ч аюулгүйн ажилтнууд гэрэл зургийн аппараттай энэ тэрүүгээр хэсүүлчлэх гадаадын харьяатад сэжиглэнгүй хандах болжээ. Харуулын албаны хүмүүс түүний үйлдэл бүрийг хардана. “Ажилчдын зураг авч яах гээд байгаа юм гээд л сэжиглэцгэнэ” хэмээн ноён Шелдон

дурсав. Уг цамхаг суурь хэсгээсээ орой хүртлээ 120 градусын мушгиа хийцтэй нь Шанхайн салхины далалтын хүчийг багасгахаар тооцсон хэрэг ажээ. Шинэ санааны ачаар барилгын хийцэд 58 сая ам.долларын бэхлэгээний материал хэмнэснийг Gensler компани тайлбарладаг.

Цамхагийг барьж дуусмагц Шанхай болоод Хятадын эдийн засаг эндээс эхлэх үү гэсэн

асуулт үүслээ. “Тэнгэр баганадсан барилгын хараал” гэж бий. Дэлхийн хамгийн өндөр барилга гэсэн алдар хүртсэн цамхаг бүр эдийн засгийн сүйрэл ёрлосон талаар эдийн засагчид онолдож гарлаа. Нью-Йоркийн Empire State Building, Куала-Лумпурын Petronas Tower, Дубайн Burj Khalifa-г эдийн засагчид жишээ болгож байв.

Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээл нь ердөө л хөөс гэсэн

бодолтой шинжээч цөөнгүй. Одоогийн байдлаар Shanghai Tower-ийн оффисын талбайн дөнгөж 60 хувийг түрээслээд байгааг тус цамхагийн төлөөлөгч мэдэгдсэн. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл нурвал ноён Шелдоны гэрэл зургуудад дүрээ мөнхөрсөн ажилчдад хамгийн хүнд тусаж, Shanghai Tower үр ашиггүй зарцуулалтын хөшөө дурсгал болон үлдэж хоцорно. **FT**



Их Британийн айл өрхийн 80 хувийнх нь дундаж орлого 2015-2016 онд өсчээ.

Орлогын тэгш бус байдал Тэтчерийн үеэс хойш үнэмлэхүй буурав

Крис Жилс

Их Британид орлогын тэгш бус байдал тэтчеризм оргилдоо хүрсэн үеэс хойш үнэмлэхүй буурсныг мягмар гарагт нийтлэсэн албан ёсны статистик харуулав. Тус улсад 2015-2016 онд ажлын байрны тоо нэмэгдэж, инфляци буурсан нь ядуу айл өрхийн амьдралын стандартыг дээшлүүлж, хүн амын үлэмж баян хэсгийн орлогыг багасгажээ.

Орлогын эрх тэгш бус байдал 1986 оноос хойш үнэмлэхүй буурсан талаарх статистик нь иргэдийн дунд хэвшиж тогтсон нийтлэг ойлголтоос зөрж байна. Их Британийн иргэд тус улсын үнэмлэхүй баян болоод хамгийн ядуу хэсгийн хоорондох цалингийн зөрөө байнга ихэссээр ирснийг одоогийн судалгаа тусгаж чаддаггүй хэмээн гомдол тавьдаг. Хөдөлмөрийн намын тэргүүн Жерми Корбин өндөр цалин олгодог явдалд хязгаар тогтоох тухай санаанаасаа саажан татгалзсан. Үүний дараа Үндэсний статистикийн газар (ONS) уг үзүүлэлтийг нийтэд танилцууллаа. “Орлогын тэгш бус байдлыг та бид дааж руулаад байж болохгүй” хэмээн ноён Корбин мэдэгдэж байв.

Шинэ статистик нь сүүлийн 50 гаруй жилийн түүхэнд Их Британид орлогын тэгш бус байдлын талаар хийсэн хамгийн цогц бүрэн судалгаанд тулгуурлажээ. Судалгаагаар гаргасан тодорхой тоон үзүүлэлтүүдийг зургадугаар сард нийтэд мэдээлнэ. Сүүлийн жилүүдэд орлогын тэгш бус байдал буурсан талаар урьд нь өөр судалгаа ч гарсан.

Их Британийн айл өрхийн 80 хувийнх нь дундаж орлого инфляцийг тооцож үзлээ ч санхүүгийн хямралаас өмнөх үетэй харьцуулахад 2015-2016 онд өсчээ. Үүнд, хүн амын 20 хувийг эзэлдэг хамгийн баян хэсгийн орлогыг оруулаагүй. Үүний зэрэгцээ нийт хүн амын 20 хувь болдог хамгийн ядуу хэсгийн орлого мөн хугацаанд 2007-2008 оны үетэй харьцуулахад 13 хувиар өслөө. Мөн дундаж хэсгийн орлого таван орчим хувиар сайжирчээ. Харин Их Британийн иргэдийн хамгийн баян чинээлэг 20 хувийг хамардаг айл өрхүүдийн дундаж орлого санхүүгийн хямралаас өмнөх үетэй харьцуулахад гурван хувиар багассан дүнтэй гарлаа.

Ядуу айл өрхийн орлого ихсэж, чинээлэг хүн амынх багассан нь орлогын эрх тэгш байдлын үзүүлэлтэд тусгалаа олов. Орлогын хуваарилалт эрх тэгш бол 0, нэг айл өрх нийт орлогыг бүхэлд нь эзэмшиж байвал 1 гэсэн дүнтэй гардаг Жинийн коэффициент хэмээх үзүүлэлт Их Британид 1990-ээд оны үед үнэмлэхүй ихэссэнээс хойш байнга тогтвортой буурч иржээ. Цалин, хөрөнгө оруулалтын орлого, тэтгэвэр орлогын эх үүсвэрийг хэмжиж үзэхэд ч “Үндсэн орлого”-ын эрх тэгш бус байдал 2015-2016 онд 0.49 гэсэн үзүүлэлттэй гарав. Энэ нь 1993 оны оргил үеийнхээс найман хувиар бага байгаа юм.

Татвар хасч тооцооны дараа үлдэх айл өрхийн цэвэр орлого ч илүү эрх тэгш буюу 2015-2016 онд Жинийн коэффициентээр 0.32 хувьтай гарлаа. Цэвэр орлогоор нь тооцсон орлогын тэгш бус байдал мөн хугацаанд 1986 оноос хойш тохиолдож байгаагүйгээр багассаныг Үндэсний статистикийн газрын судалгаа харуулав. Энэ үзүүлэлт 1993 оны оргил үеийнхээс даруй 14 хувиар багасчээ.

Орлогын тэгш бус байдал багассаныг баталсан судалгаа нь иргэдийн дунд нийтлэг, амьдралын түвшиндээ сэтгэл хангалуун бус байдаг явдалтай зөрчилдөж байна. Энэхүү зөрчил нь санхүүгийн хямралаас хойш Их Британид айл өрхийн орлого хэт сул эрчтэй өсөж ирсэнтэй холбоотой хэмээн Resolution Foundation-ий эдийн засагч Мэтью Уиттэйкер тайлбарлав.

Их Британид 2007-2008, 2015-2016 оны хооронд айл өрхийн орлогын жил тутмын дундаж өсөлт нь Тэтчерийн засаглалын үе болон 1990-ээд, 2007-2008 оны үеийн үзүүлэлтийн хагаст ч хүрэхгүй байгаа юм. “Амьдралынхаа нөхцөлд бүгд дургүйцэж байхад эрх тэгш бус байдал багаслаа гэх нь таагүй хэрэг” хэмээн ноён Уиттэйкер өгүүллээ.

Тус улсын нийгэмд 2007-2008 онд орлого хамгийн сайн хүртсэн хэсэг нь тэтгэвэр авагчид. Мөн хугацаанд тэтгэвэр авагчдын орлого 13 хувиар нэмэгдсэн бол тэтгэврийн бус насныхны цэвэр орлого 1.2-оор багасчээ. Их Британийн хөдөөгийн таван сая айл өрхийн дундаж орлого хотын 20 сая айл өрхийнхөөс илүү байгаа нь судалгаагаар мөн баталж байна. Дэлхийн айлйн дундаж цэвэр орлого 35500 фунт стерлинг байхад хотын айлынх ердөө 32500 байв.

Resolution Foundation, Санхүүгийн судалгааны хүрээлэнгийн шинжээчдийн судалгаа зөв байх аваас 2016 он нь орлогын тэгш бус байдал буурсан сүүлчийн жил. Учир нь эрх баригчид тэтгэврийн бус насныханд олгодог төрөл бүрийн тэтгэмжийг 2020 он хүртэл дөрвөн жилийн хугацаатай **FT**

Таваарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг хурдасгана

Шон Доннан

Таваар экспортлогч хөгжиж буй улсууд төдийгүй АНУ зэрэг хөгжингүй орнууд сэргэх хэрээр дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурдац энэ онд эрчимжинэ хэмээн Дэлхийн банк үзэж байна. Гэхдээ энэ оноос АНУ-д Трампын засаг захиргаа ажиллаж, Европ тивд сонгууль болохтой уялдан эдийн засгийн бодлого өөрчлөгдөж, протекционизмын шинэ тойрог эхлэж болзошгүйг тус банк давхар анхааруулав.

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2016 онд санхүүгийн хямралаас хойш хамгийн сул буюу 2.3 хувьтай байлаа. Энэ онд байдал сайжирч, уг үзүүлэлт 2.7 хувьтай болно. Хөгжингүй эдийн засгийг бүхэлд нь авч үзэх тохиолдолд өсөлт үл ялиг хурдасч 1.8 хувь хүрнэ. “Дэлхийн эдийн засаг хэдэн жилийн турш ураг хугарам өсөлттэй явж ирсэн бол цаашид дүр зураг өөрчлөгдөх нь” хэмээн Дэлхийн банкны ерөнхийлөгч Жим Ён Ким мэдэгдлээ.

“Сайн мэдээ гэвэл сэргэлт эхэлсэн явдал. Хэрвээ 2016 оныг ёроолдоо тулсан жил гэж үзвэл сэргэлт чухам ёроолоосоо эхэллээ” хэмээн тус банкны жил тутмын Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв (Global Economic Prospects) тайлангийн удирдагч Айхан Косе тайлбарлав. “Юутай ч өсөлтөд улс төрийн тодорхой бус байдал зэрэг зарим эрсдэл заналхийлж байгааг харгалзан үзэх нь зүйтэй” хэмээн Косе анхааруулж байна.

АНУ-ын эдийн засаг 2017 онд 2.2 хувиар өсөх таамгийг Дэлхийн банк дэвшүүллээ. Тус банк өнгөрсөн онд уг өсөлтийг 1.6 хувиар тооцоолж байв. Эдийн засгийн өсөлтийг дэмжих үүднээс татвар багасгаж, дэд **FT**

бүтцэд зориулах зардлыг өсгөн, зохицуулалтыг бууруулахаар АНУ-ын Ерөнхийлөгчид сонгогдогч Дональд Трамп амласан. Эдгээр арга хэмжээний ачаар энэ оны өсөлтийн тооцоо анхныхаасаа илүү өөдрөг болжээ. Харин евробусийн эдийн засаг 1.5, Японы 0.9 хувиар өсөх төлөвтэй. АНУ-ын эдийн засгийн өсөлт сайжрах нь дэлхийн эдийн засгийн бусад хэсэгт ч сайнаар нөлөөлнө. “АНУ-д гарах өөрчлөлт дооцоо хамраад өнгөрөхгүй” хэмээн ноён Косе тайлбарлав.

Харин ам.долларын ханш чангарч, АНУ-ын бодлогын хүү ихсэх нь хөгжиж буй эдийн засагтай улсуудын компанийн өр эзэмшигчдэд хүнд тусна хэмээн тэрбээр үзлээ. Энэ онд АНУ-д өсөлт хурдасч хэрээр таваар экспортлогч хөгжиж буй улсуудын эдийн засаг 2.3 хувиар сайжирна. Хөгжиж буй зах зээлийн эдийн засаг сүүлийн хоёр жилийн турш зогсонги байгаа юм.

Таваар экспортлогч хөгжиж буй ихэнх улсын эдийн засаг энэ онд жилийн өмнөхөөс хавьгүй сайжрах ч үнийн өөрчлөлт, цаашдын таагүй нөлөөнд аанай л эмзэг байх талаар ноён Косе анхаарууллаа. Мөн 2010 онд 10 хувьтай байсан дэлхийн хөрөнгө оруулалтын өсөлт 2016 онд 3.5 хувь ч хүрэхгүй болтлоо буурсан чиг хандлага энэ онд хэвээр үргэлжилнэ.

Харин сүүлийн таван жилийн турш сул үзүүлэлттэй явж ирсэн дэлхийн худалдаа эргэлтийн хэмжээ энэ онд сайжрах төлөвтэй. Өнгөрсөн онд 2.5 хувиар өссөн дэлхийн худалдаа энэ онд таваарын үнийн сэргэлттэй уялдан 3.6 хувиар өсөхөөр байгаа юм. **FT**

Биотехнологийн салбарын сулхан эхлэл


Адам Самсон, Николь Буллок
Америкийн биотехнологийн хувьцаа 2017 оныг бүрхэг төлөвөөр угтлаа. Тус салбар өнгөрсөн онхоос нэлээд буурч, Уол Стритийн үзүүлэлт дотор сүүл барих шинжтэй болов. Nasdaq-ийн биотехнологийн индекс 7.8 хувь өссөн боловч S&P 500 өргөн ангиллаар дөнгөж 1.6 хувийн өсөлт гарсан аж. Дональд Трамп сонгогдсоны дараа санхүү болон эрчим хүчний хувьцааны үнэ дээшилсэн. Ингэснээр арваннэгдүгээр сард түүхэн дээд хэмжээндээ хүрсэн S&P 500-ийн индекс одоо тогтмолжиж, энэ хоёр салбарын үзүүлэлт 2016 оны хаалтын түвшинд очлоо.

Энэхүү завсарлагааны үед 2016 онд хамгийн муу үзүүлэлттэй байсан биотехнийн хувьд түр ахих боломж бүрдэв. Тус салбарын шинэ жил дээшилсэн шалтгааны нэг нь “Нэгдүгээр сарын нөлөө” гэж ConvergeX фирмийн зах зээлийн стратегийн шинжээч Николас Колас дүгнэжээ. Тэрбээр “Нэг жилд нь хамгийн их алдагдал хүлэсэн хувьцаа хоёр дахь жилд өгсдөг жамтай” гэсэн байна. 2016 онд S&P 500-ийн биотехнологийн индекс 9.5 хувьтай байсан. Гэвч хөрөнгө оруулагчид тус салбарын хувьцаанаас дөлснөөр 21.7 хувиар унасан билээ.

Түүнчлэн Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр эмийн үнийн өсөлтийн асуудал маргааны эсдэв болсон нь хувьцааны үнэд сөрөг нөлөө үзүүлсэн. Трампын ялалтын дараа зохицуулалт зөвлөрөх хүлээлт үүссэн учир түр зуур биотехнийн хувьцаа өсөх хандлага ажиглагдв. Гэвч шинээр сонгогдсон Ерөнхийлөгч эмийн үйлдвэрлэлд хэрхэн хандах нь тодорхойгүй байгаа тул хүлээлт болон өсөлт намжжээ. Иймээс долоон жил дараалан өсөж, үнэлгээ нь улам дээшилж байсан биотехнийн хувьцаанд эргэлт гарч, сул үзүүлэлтийн нэг болж хувирав.

2016 он эхлэхэд Nasdaq-ийн биотехнийн индекс 12 сарын хугацаанд 27.1 дахин нэмэгдсэн ашиг авчрахаар үнэлэгдэж байв. Харин нийт зах зээлийн хувьд уг үзүүлэлт 16.6 байсныг S&P-ын дэлхийн зах зээлийн судалгаанд дурдсан байдаг. Гэвч үнэлгээний түвшин он гараад буурч, Nasdaq-ийн биотехнийн индекс 24.7 руу унасан бол S&P 500-ийнх 17.7 болсон байна. Morgan Stanley банкны шинжээч тус салбарын компаниуд гэрээ байгуулахад зарцуулах бэлэн мөнгө ихтэй байгаа гэжээ. Тухайлбал, Dealogic data байгууллагын мэдээгээр оны эхний 10 хоногт тус салбар 6.9 тэрбум ам.долларын өртөгтэй гэрээ хийгдсэн 2016 оны мөн үеийн 1.1 тэрбум, 2015 оны мөн үеийн 322 саяа хамаагүй давсан үзүүлэлт юм.

Даваа гарагт Японы Takeda компани АНУ-д байрлалтай Agid Pharmaceuticals-ыг 5.2 тэрбум ам.доллараар худалдан авах гэрээ хийж, хавдар судлалын чиглэлд үйл ажиллагаагаа идэвхжүүлэв. Ховор төрлийн хавдарт эмчилгээ хийдэг тус компанийн хувьцаа бараг 0.75 хувиар өссөн байна. Харин Цахиурын хөндийн томоохон компаниудын тусламжтайгаар дээшилж буй технологийн салбар он гараад мөн л чангарах хандлагатай боллоо. Тухайлбал, Facebook-ийн хувьцаа 8.8 хувь өссөн бол Alphabets-ийнх 4.4 хувиар дээшлэв. Технологийн дэлхийн хамгийн аварга компани Apple-ийн хувьцаа 3.3 хувиар чангарчээ.



BBM©

Трамп хүргэнээ ахлах зөвлөгчөөр томиллов

Корнни Вивер
30 гаруй настай Трампын хүргэн Ойрх Дорнод болон худалдааны асуудлаар Ерөнхийлөгчид нөлөө үзүүлэх гол хүн болж байна. Даваа гарагийн үдэш шинэ засаг захиргааны хамгийн нөлөө бүхий зургаан хүн конгресс дэх БНН-ын спикер Пол Райаны өрөөнд цугларч, татварын шинэчлэлийн талаар намын төлөвлөгөөг хэлэлцжээ. Зөвлөгөөнд Трампын захиргааны тэргүүн Рейнс Прайор, Сангийн сайдад нэр дэвшсэн Стивен Мнухин нар байлаа. Гэвч дөнгөж мямар гарагт 36 насны төрсөн өдрөө тэмдэглэсэн Трампын хүргэн Жаред Кушнер хамгийн эрх мэдэлтэй нь байсан юм. Уг уулзалтаас хоёрхон цагийн өмнө тэрбээр Трампын ахлах зөвлөгчид албан ёсоор томилогдсон юм. Кушнер хэдэн сарын турш албан бус зөвлөхийн үүрэг гүйцэтгэж ирсэн аж.

Энэ залуу Трампын засаг захиргаанд Ойрх Дорнодын асуудал, худалдааны бодлого, төр болон хувийн хэвшлийн шинэ харилцаа бий болгох талаар гол зөвлөгөө өгөх болно.

Олны нүднээс далд Кушнер, эхнэр Иванкагийн хамт шинэ Ерөнхийлөгчийн хамгийн итгэлтэй хүмүүс байж, зөрчил үүсвэл намжаах үүрэг гүйцэтгэх байх. Трампын сурталчилгаа эхлэх үед тэд мөн ийм үүрэгтэй байсан бөгөөд шинэ харилцаа тогтоох, Цагаан ордноос шийдвэр гаргахад оролцох боломжтой. Гэвч энэ нь Кушнер, Иванка Трамп нарын аль аль нь төрийн албанд ажиллаж байгаагүй учир урьд үздэггүй туршлага. Найз нөхдийнх нь хэлснээр энэ томилолт гэр бүлийн хоёрын холын хүсэлд нийцжэ байж болох юм.

Жаред Кушнер эцэг нь улс төрийн авлигын хэргээр шоронд байх завсар Нью Жерси дэх гэр бүлийнхээ үл хөдлөх хөрөнгийн эзрэлтийг удирдаж эхэлжээ. Ноён Трамп Ерөнхийлөгчийн сунгаанд өрсөлдөх үед хосууд сурталчилгааны ажилд оролцож, нэр дэвшигчийг дагалдан явсны дээр Иванка эгхийнхээ нэрийн өмнөөс үг хэлж байсан. Иванкагаар дамжуулж эхнэртэйгээ танилцсан, Балтиморын үл хөдлөхийн үе дамжсан эзэн Рид Кордши “Тэр

хоёр хоёулаа маш амжилттай бизнес бүтээсэн. Үүнийгээ залуу насандаа маш түргэн амжуулж чадсан” хэмээв. Тэрбээр цааш нь “Том үйл ажиллагааг хэрхэн үр ашигтай, амжилттай удирдах туршлага олж авсны дээр хоёулаа маш бодлоготой удирдагчид. Тэдэнтэй харилцан ажиллахад/би тэднийг бизнесээ хэрхэн удирдаж байгааг ч ажигласан/ тэд эрхэлж буй зүйлийнхээ талаар бүх талын мэдээлэл авахад асар их хүчин чармайлт гаргадаг нь харагдсан” гэж үнэлжээ.

Тэр хоёр олны дунд нэртэй хүмүүс болсон ч гэртээ еврей шашны жаягийг хатуу баримтлан амьдардаг аж. Иванка гэрлэхдээ уг шашинд орсон юм. Кушнер уулзалтын үеэр анхааралтай сонсон идэвхтэй оролцдоггүй бол Иванка “Өрөөний бүх хүчилтөрөгчийг сороод авчих шиг оролдог” гэж нэг ажиглагч ярьсан байдаг. Вашингтон ирээд энэ хоёр олон нийтийн арга хэмжээнд нэлээд оролцох бөгөөд Иванка заримдаа тэргүүн хатагтайн үүргийг гүйцэтгэх байх гэсэн хүлээлт үүсчээ.

Түүний хойд эх Меланиа Трамп хүүгийнхээ хичээлийн жилийг дуусгахын тулд хэсэгтээ Нью-Йоркт байх юм.

Кушнерийн гэр бүл Вашингтоны Калорама дүүрэгт нүүж ирэхээр зарласан нь Барак, Мишель Обама нарын шинэ байрнаас ойрхон харагдах газар. Монреалын их сургууль дахь АНУ-ын Ерөнхийлөгчийн түүх судлалын профессор МкЖил “Тэднийг хаана уриалгахын тулд авч, эсвэл хаана урихаас татгалзахыг ажиглавал сонин байх болно. Тэд нийслэлд хаа сайгүй очих байх. Хямд үнийн Трампууд болон хувирах боломжтой” хэмээн ярьжээ. МкЖил энд Кушнерийнхэн арванхоёрдугаар сард Хавай руу явж амрахдаа хямд сургууль нислэг сонгодог онгоцонд байсан нэг зорчигч тэднийг эсэргүүцэн улс төрийн бяцхан үймээн тарьсныг дайруулан хэлсэн бололтой.

Гэвч одоо ноён Кушнер албан ёсоор Цагаан оронд очих болсноос үүсэх ашиг сонирхлын төлөө хэрхэн шийдэх нь гол асуулт болоод байна. Сонгуулийн дараахан Кушнер

үл хөдлөхийн Анбан компанийн захирал Хятадын улс төрийн хүрээнд нэн ойр хүнтэй уулзаж, гэрээ байгуулах талаар хэлэлцээ хийсэн. Тэрбээр АНУ-ын хуулийг зөрчихгүйн тулд албан тушаалд томилогдоод цалин авахгүй гэж мэдэгдээд байгаа. 1967 онд батлагдсан хууль ёсоор АНУ-ын Ерөнхийлөгчид гэр бүлийн ойрын гишүүдээ холбооны агентлагийн тэргүүнээр томилохыг хориглосон байдаг. Үүн, хүүхдүүдийнх нь энхэр, нөхөр ч мөн адил хамаарна.

Ноён Кушнер өөрийн үл хөдлөхийн болон мэдээллийн компаниудын эрх мэдлийг шилжүүлэхээр төлөвлөж буйгаа зарласан. Жишээ нь, гэр бүлийн Kushner Companies бүлгийн захирлын албан тушаалаа өгч, 2008 оноос хойш эзэмшиж буй New York Observer сонингоо худалдаагаар шийджээ. Түүнчлэн Kushner Companies-ийн эзэмшлийн 666 Fifth Avenue хэмээх Нью-Йоркийн өндөр барилга дахь нэрийн хувьцаагаа шилжүүлэхийг амласан байна.



Саудын Араб Исламын бонд гаргана

Элэйш мур, Симеон Керр
Саудын Араб дээд хэмжээнд хүрээд буй төсвийн алдагдлаа нөхөхийн тулд хоёрдугаар сараас дэлхийн зах зээлд сукук гэдэг Исламын бонд худалдаагаар зөвөж байна. Исламын шариаат хуульд нийцдэг сукукийг голдуу булангийн орнууд худалдан авна гэж тооцжээ. Эндээс босгосон хөрөнгийг, цаашлаад газрын тосноос хэт хамааралтай эдийн засгаа төрөлжүүлэхэд зарцуулах аж. Өнгөрсөн онд Саудын Араб хөгжиж буй орнуудын дотор дээд амжилт тогтоож, 17.7 тэрбум ам.долларын бонд гаргаад 67 тэрбумын санал татаж чадсан юм.

Анхны бондыг арилжаалахад оролцсон 10 банкыг бүгдийг нь энэ удаад урихгүй. Харин харин Citigroup, HSBC, JPMorgan банкууд жагсаалтад үлдэх байх гэж уг төслийг сайн мэдэх нэг ажилтан ярьжээ. Газрын тосны хамгийн том үйлдвэрлэгчийн хувьд Саудын Араб 2014 оны үнэ уналтад ихээхэн өртсөн. Үүний улмаас Засгийн газрын зардлыг Агапсо нефтийн компанийн хувьцааг санал болгож байв. Арваннэгдүгээр сард ОПЕК-ийн гишүүд олборлолтоо хумих тохиролцоонд хүрсний дараа түүхий нефтийн үнэ 55 ам.доллар дээр тогтсон авч гурван жилийн өмнөх 100-гийн босгыг давах



BBM©

найдар хомс. Fitch Ratings-ийн Исламын санхүүгийн мэргэжилтэн Башар Натоор “Эдийн засгаа төрөлжүүлэх нь шинэ зах зээлийн хувьд бодит шаардлага. Гэвч нефтийн үнэ унасан нь Сауд шиг орнуудад үүнийг зайлшгүй болголоо. Доогуур үнэ тус улсын банкин дахь нөөцийг багасгаж, банкуудын зээлдүүлэх эрмэлзлэлд сөрөг нөлөө үзүүлсэн.

Иймээс тэд санхүүгийн өөр эх үүсвэр хайх болсон юм” хэмээн тайлбарлав.

Катар, Абу Даби, Оман, Бахрейн зэрэг Персийн булангийн улсууд үнэ уналтын дараа капиталын зах зээлд хандсан бөгөөд Fitch-ийн таамгаар булангийн зээлдэгчид сукук гаргах төлөвтэй байгаа аж. Зарим компани шариагийн хуульд захирагдсан эзэл авахыг

эрмэлзэж байгаа бол зарим нь Исламын хөрөнгө оруулалтын санхүүжилтэд хамрагдахыг хүсэж байна. Сукукийн энгийн бондоос ялгарах онцлог хүүг хориглодог Исламын журмыг зөрчихгүй байх ёстой. Энэ нь томоохон хөрөнгийг хамтран эзэмших байдлаар хэрэгждэг.

Өнгөрсөн онд Пакистан, Индонез, Малайз зэрэг исламын шашинт орнууд 9.4 тэрбум

ам.долларын сукук худалдсан нь 2015 оны 6.3 тэрбумаас нэлээд өссөн дүн болохыг Dealogic байгууллага мэдээлэв. Гэвч зээлийн шинжээчид сукукийн хэмжээ нэмэгдвэл зах зээлийг стандартчилах шаардлагатай гэж үзэж байна. Саудын бондын үнэ анхны арилжаанаас хойш унасан боловч өгөөж нь өсөж 3.25 ам.доллараас 3.7 хүртэл дээшилжээ. Энэ хэлбэлзэл зээлийн бондын зах зээл, тухайлбал Америкийн бондын өгөөж буурсантай холбоотой байж болох юм.

Саудын Араб 297 тэрбум риалд (72.9 тэрбум ам.доллар) хүрсэн төсвийн алдагдлаа нөхөхийн тулд гадаад, дотоодын эх сурвалжаас зээл авч, гадаад дахь нөөцөөсөө ашигласан. Тус улсын Сангийн яам эдийн засгийг төрөлжүүлэх зорилготой Үндэсний өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 42 тэрбум риалыг хөрөнгийн зах зээлээс босгох шаардлагатай. Тус улс 2016 онд 12.3 хувь байсан Үндэсний нийт бүтээгдэхүүн ба зээлийн харьцааг 30 хувьд хүргэх чиг барьж байгаа юм. Саудын Арабын Сангийн сайд Мохаммед Жадаан арванхоёрдугаар сард “Засгийн газар тохиромжтой цонх нээгдэхэд өрийн зах зээл рүү дахин хандана” гэж мэдэгдсэн билээ.



Эдийн засаг

ТҮҮХИЙ ЭД

Найдвар тээсэн зэс

Зэсийн ханшийн сэргэлт ирж байна

Г.Байгал
@baigalZGM

Зэс “гялалзана”. Энэ оны хамгийн өнгөлөг таваараар шинжээчид шаргал металлыг нэрлэж байна. Зургаан жил тасралтгүй уруудсан зэсийн ханшийн “үнэгүйдэл” дуусах нь. Үнийн уналт ард хоцорсныг хэлэх шинжээчдийн дуу хоолой чангарч байна. Ялангуяа, ханш буураад буцаад сэргэсэн энэ өдрүүдэд улам ч чанга болов.

Шаргал металлын ханш шинэ онтой уралдан уруудсан. Аравхоёрдугаар сарын эхээр 6000 ам.долларыг шүргэж байсан ханш хэд хоног дараалан буурлаа. Энэ үед зэсийн сэргэлтэд эргэлзэх хандлага ч байв. Гэсэн ч хэсэг доошилсон ханш эргээд дээшлэв. Лондоны металлын биржид лхагва гарагийн байдлаар тонн зэс 5785 ам.доллартай тэнцэж байна. Ханш гурван хувиар чангарч, нэг сарын дээд цэгт тулсан нь энэ.

Зэсийн хэрэглээний тал хувийг дангаар “залгидаг” БНХАУ-ын хэрэглээний болон үйлдвэрлэлийн үнийн индекс эрчимжжээ. Тус улсын үйлдвэрлэлийн үнийн индекс өнгөрсөн сард сүүлийн таван жилийн оргилд хүрсэн байна. Энэ нь урд хөрийн үйлдвэрлэл өсөлттэй байгааг илтгэв. Улмаар зах зээлд ч зэрэг “мессэж” боллоо.

Сайн мэдээ үүгээр дуусахгүй. Дэлхийн “Номер 1” эдийн засаг 500 тэрбум ам.долларын сураг дуулгаад удаж байна. АНУ хагас их наяд “ногоон”-оор дэд бүтцээ хөгжүүлнэ. Энэ аварга бүтээн байгуулалт зэсийн эрэлтийг дэмжиж, үнийг өсгөх нь дамжиггүй. Америкаас гадна Их Британид ч ийм төлөвлөгөө бий. Европын холбооноос өрх тусгаарлаад удаагүй энэ улс дэд бүтцийн төслүүдээр дамжуулан бизнесээ идэвхжүүлэх аж. Их гүрнүүдээ зэсийн эрэлт өсөх дохио ирж байна. Энэ нь зэсийн ханш сэргэнэ гэж зоригтой хэлэх эхний шалтгаан болжээ.

Өсөлт дагуулсан эерэг мэдээтэй зэрэгцээд нийлүүлэлтэд эрсдэл учирч магадгүй. Дэлхийн зэсийн хамгийн том үйлдвэрлэгчид маргаан дэгдлээ. Чилийн “Escondida” уурхайд хөдөлмөрийн маргаан үүсээд удаж байна. Одоо улам ч даамжирч байгаа аж. “Escondida” бол аварга уурхайн нэг. Дэлхийн нийт үйлдвэрлэлийн таван хувийг дангаар хангадаг гээд бодохоор энэ уурхайн зах зээлд үзүүлэх нөлөө чамгүй их.

“BNP-Paribas”, “Rio Tinto”-гийн хамтран эзэмшдэг уурхай 2015 онд 1.3 сая тонн зэс үйлдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, сая давсан тонн зэсийн нийлүүлэлтэд эрсдэл учраад байна. “Reuters” агентлаг мэдээлснээр маргааныг эцэслэх боломж бүрхэг байгаа аж. Уурхайн ажилчид цалин нэмж,



урамшуулал олгохыг шаардсан. Гэвч удирдлагууд нь урамшуулал олгох боломжгүй гэдгээ мэдэгджээ. Гэхдээ ажилчид болон удирдлагуудын хурал энэ сарын сүүлээр болох товтой байгаа юм. Тиймээс салбарынхан Чили тийш чих тавиад байна. Энэ нь ч учиртай.

Өнгөрсөн жилүүдэд болсон ажилчдын бослого, маргаан зах зээлд хүчтэй нөлөөлсөн. “Escopida” тэргүүтэй том уурхайнууд зэсийн гарцаа бууруулахаа мэдэгдсэнээр дараа ханш нүд ирмэхийн зуур дээшилж, 6000 ам.долларт хүрч байсан юм. Энэ мэт шалтгааны улмаас Чилиэс ирсэн мэдээ зах зээлд хүчтэй нөлөөлж байна. Дээрээс нь Чилийн нийлүүлэлт ирэх жилүүдэд буурах хандлагатай байгааг энд сануулъя.

Дэлхийн зэсийн үйлдвэрлэл 2015 онд 18.7 сая тоннд хүрчээ. Олон улсын зэсийн судалгааны группээс энэ онд үйлдвэрлэл өсөхгүй гэж таамаглаж байна. Улмаар 2018 онд зэсийн зах зээл тэнцвэржих төлөвтэй.

Үүнээс үзэхэд нийлүүлэлтэд эрсдэл, эрэлтэд өсөлт ажиглагдаж мэдэхээр байна. Тиймээс ч шинжээчид зэс “гялалзвал” бүү гайх хэмээн сануулж байгаа нь энэ. Олон улсын шинжээчид зэсийн ханшийг богино хугацаанд хэрхэн таамагласныг харцгаая. Дийлэнх нь 5000 ам.доллараас давсан таамаг дэвшүүлсэн байна. Зах зээлийн хамгийн бүүдлэг төлөв танилцуулдаг “Goldman Sachs” хүртэл тонн зэс энэ оны эхний улиралд 6200 ам.долларт хүрнэ гэж таамаглаж байна.

Шинжээчдийн дэвшүүлсэн эдгээр таамаг манай төсөвт суулгасан үнээс өндөр. Монгол Улс 2017 оны төсөвтөө тонн зэсийг 4693 ам.доллараар борлуулахаар тооцсон. Зэсийн баяжмалын экспортоос 570 тэрбум төгрөг олохоор төсөвлөсөн юм. Энэ онд манай зэсийн салбарын зүтгүүр нь “Оюутолгой” болно. Тус ком-

пани 850 мянган тонн зэсийн баяжмал борлуулж, 462.3 тэрбум төгрөгийн татвар төлөхөөр төсөвт суулгажээ. “Эрдэнэт” үйлдвэр 650 мянган тонн зэсийн баяжмал, 4219 тонн молибдены баяжмал олборлож, 175.4 орчим тэрбум төгрөгийн татвар, ногдол ашгийн орлогыг төвлөрүүлжээ тооцжээ. Сүүлийн 2-3 жилийн хугацаанд манай улсын шаргал металлын олборлолт 40 хувиар ашиад байгаа. Олборлолт оос гадна нөөц ч дээшилж буй. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэдээлснээр сүүлийн зургаан жил зэсийн хайгуулыг эрчимжүүлж, 80 орчим илрэл, 300 гаруй эрдэсжсэн цэг тогтоосон байна. Ингэснээр 2.3 сая тонн таамаг нөөц илрүүлж, зэсийн нөөцийг зузаатгасан болохыг Ашигт, малтмал, газрын тосны газраас мэдээлэв. Мөн цаашид ч нөөц нэмэгдэх боломжтойг дурджээ.

Үүнээс үзэхэд энэ онд Монгол Улс төлөвлөсөн орлогоо зэсийн салбараас олох боломж байна. Ингээд зогсохгүй зэс “гялалзвал”, бид ч ахиу ашиг хүртэх нь. [ЗГМ]

ӨДӨР БҮР ДРАКЕРТАЙ ХАМТ

Зохион байгуулалтын инерц




Үнэнтэй нүүр тулахад хүргэдэг дэг журам байх хэрэгтэй

“Өдөр бүр Дракертай хамт” номноос “Зохион байгуулалтын инерц” хэсгийг онцоллоо. Зөв зүйлийг хийх урам зориг, шинэ санаа өгөх 366 өдрийн хичээлийн эхнийх танд ийн хүрч байна. “Өдөр бүр Дракертай хамт” ном нь Питэр Ф.Дракерн үндэслэлийн гол санаануудыг багтаан хураангуйлан гаргасан бүтээл юм. Үр бүтээлтэй захирлын ширээний ном болох энэхүү бүтээл нь гүйцэтгэлд чиглэсэн болохыг Питэр Ф.Дракер тодотгосон удаатай. Тэрбээр “Сайнаас агуу руу” номын зохиолч Жим Коллинз-д “Өөрийгөө дайчилж хүмүүст тустай нэгэн бол” гэж хэлсэн тухай Жим Коллинз хожим нь өгүүлсэн байдаг. Питэр Ф.Дракер нь менежментийн ухааныг үндэслэгч бөгөөд ХХ зууны сүүлийн хагасын менежментийн хамгийн нөлөө бүхий сэтгэгчдийн нэг юм.

Бүх байгууллагууд ямар нэгэн сайжруулалт болон шинэчлэлтгүйгээр удаан хугацаанд ашигтай ажиллаж чадах

Зэсийн ханшийн төлөв-2017 оны I улиралд (ам.доллараар)

Компани	Ханш (ам.доллараар)
“Goldman Sachs”	6200
“JPMorgan”	4900
“Deutsche Bank”	4400
“Citigroup”	6000
“Codelco”	5200
“ABN AMRO”	5600
“Macquarie”	5350
“Commerzbank”	5200
BMI	5100
“Society Generale”	4200



Зэсийн ханш сүүлийн нэг сард (ам.доллараар)

ч амжилтгүй болон үр бүтээлгүй байдлаас хэзээ нэгэн цагт салахаас өөр сонголтгүй болдог. Засгийн газар, эмнэлэг, арми зэрэг байгууллагын хувьд эдийн засаг л ганц хязгаарлалт нь юм. Бүх байгууллага өөрчлөгдөх чадамжтай байх ёстой. Бидэнд бизнест буй зах зээлийн туршилт болон ашигт байдлын хэмжүүртэй адил бусад байгууллагуудад тохирох зарчим, шалгуур хэрэгтэй. Тэдгээр зарчим, шалгуур нь харилцан адилгүй байх болно. Бүх байгууллагад тэднийг үнэнтэй нүүр тулахад хүргэдэг дэг журам байх хэрэгтэй.

Гүйцэтгэх зүйл: Таны ашгийн бус байгууллага үйл ажиллагаагаа хянах нарийн зарчим, шалгууртай, эсэхийг нягтална уу.

“Өдөр бүр Дракертай хамт” номын талаар АПУ компанийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг “Үйлдвэрийн менежмент үнэхээр амаргүй, нарийн түвэгтэй байдаг зүйл. Би анх компанийн, тэр тусмаа үйлдвэрийн үйл ажиллагааг удирдах арга зүйн талаар үйлдвэрийн ахмад удирдлага хамт олноос их зүйлийг сурч ажил амьдралдаа хэрэгжүүлж үр дүнг нь ч мэдэрч байна. Залуучуудад болон бусад, зөв оновчтойгоор сайн удирдах талаар өөрөөсөө илүү туршлагатай хүмүүсээ, шууд болон бүтээлүүдээс нь суралцах нь маш зүйтэй шүү хэмээн бодит хэмжүүр байдаг. Тиймээс

ЗГМ ТОВЧХОН

» ТҮҮХИЙ ЭД

50.96

Ам.доллар . WTI төрлийн газрын тосны ханш 50.96 ам.доллартай тэнцэж байна. Тус түүхий эд нь даваа гарагаас таван хувиар буураад байгаа юм.

2.8

Хувиар. Төмрийн хүдрийн ханш 2.8 хувиар чангарав. Ингэснээр мягмар гарагаас хойш 5.5 хувиар чангарлаа.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

58

Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны 58 компани байна. Үүний 42 нь арилжаанд оролцох эрхтэй.

» ҮНЭТ ЦААС

5.3

Тэрбум төгрөг. Засгийн газрын есөн сарын хугацаатай 60 мянган ширхэг үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжлаа. 16.99 хувийн хүүтэй үнэт цаасыг 5.3 тэрбум төгрөгөөр борлуулжээ.

» ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

S&P зэрэг олон улсын үнэлгээний агентлаг Ази, Номхон далайн бүсийн зээлжих зэрэглэлийг 2017 онд тогтвортой гэж үнэллээ.

» ДЭЛХИЙД

5.11

Хувь. “Rio Tinto” компанийн хувьцааны ханш Лондоны хөрөнгийн биржид 5.11 хувиар өслөө. Мөн “FTSE 100” индексийг өсөлтөөрөө тэргүүлсэн байна. Сүүлийн нэг жилд хувьцааны ханш нь 89 хувиар чангарчээ.

4

Тэрбум ам.доллар. Азербайжан улс энэ онд Төрийн өмчит баялгийн сангаас нийт дөрвөн тэрбум ам.долларыг зорин төв банканд шилжүүлэхээр болжээ. Азербайжаны төв банк энэ санхүүжилтийг макро эдийн засгийг тогтворжуулахад ашиглах аж.

» ТЕХНОЛОГИ

2.6

Тэрбум ам.доллар. БНХАУ-ын онлайн худалдааны “Alibaba” групп жижиглэн худалдааны “Intime” компанийг 2.6 тэрбум ам.доллараар худалдсан аргаар санал тавилаа. Одоогоор “Alibaba” компани “Intime”-ийн 28 хувийг эзэмшдэг. Хэрэв “Intime” саналыг зөвшөөрөв эзэмшлийн хувь нь 74 болж нэмэгдэх юм.

» ЭРЧИМ ХҮЧ

163

Тэрбум ам.доллар. Арабын нэгдсэн Эмират улс сэргээгдэх эрчим хүчний 163 тэрбум ам.долларын төсөл хэрэгжүүлнэ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ, доллар	2497.66
Евро	2637.15
Япон, иен	21.52
ОХУ, рубль	41.53
БНХАУ юань	360.57
БНСУ вон	2.09

УУЛ УУРХАЙ

“Баян хөндий”-н алтны гол судал 2000 метрээр нэмэгджээ


Т.Элса
Шинжээч

Канадын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Erdene Resource Development” компани “Баян хөндий” төслийн өрөмдлөгийн үр дүнг танилцууллаа. Тус компанийн мэдээлснээр өндөр эрдэжилттэй, газрын давхаргатай ойр алтны гол судал нь зүүн хойд зүгт 200 метрээр нэмэгджээ. “Erdene Resource Development” нийт найман кононогт 1370 метрийн гүнд өрөмдлөг хийсэн. Үүнээс зургаан кононогт хийсэн өрөмдлөг нь

алтны эрдэжилттэй давхаргад хүрсэн байна. Иймээс нөөцийн хэмжээ анх тооцооноос их байх магадлалтай гэж үзжээ. Тус компани алтны судлын шинэ гэгж нэрлэж байгаа. “Газрын давхаргад ойр, өндөр зэрэглэлийн алтны эрдэжилт байгааг судалгааны үр дүн баталсан” гэдгийг “Erdene Resource Development” компанийн гүйцэтгэх захирал Питер Акерлий онцолж байна. Мөн тэрбээр 2017 онд “Баян хөндий” болон “Алтан нар” төслийн хүрээнд зорилтот хэсгүүдэд өрөмдлөгийн ажлаа эхлүүлнэ.

Эдийн засаг

Азийн хувьцаануудын ханш өслөө



Hang Seng индекс сүүлийн нэг сард (нэгжээр)

Азийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байв. Ази, Номхон далайн бүсийн жишиг индекс 0.3 хувиар дээшилсэн байна. Тухайлбал, Хонконгийн хувьцаануудын ханш 10 өдөр дараалан өссөн. Hang Seng Composite индекс 0.5 хувиар дээшилжээ.

Тэрчлэн БНСУ-ын хөрөнгийн зах зээлийн өсөлт 2015 оны долдугаар сараас хойш анх удаа Азийг тэргүүлэв. БНСУ-

ын жишиг индекс Kospi 1.6 хувиар чангарсан байна. Өмнөд Солонгосын “Samsung Electronics” компанийн хувьцааны ханш гурван хувиар чангарсан. Хятадын хэрэглээний болон үйлдвэрлэлийн үнийн индекс өсөлттэй гарсан. Энэ нь зах зээлд эергээр нөлөөлөв.

Уул уурхай болон технологийн компаниудын үнэт цаасны ханш өссөнөөр Австралийн S&P 200 индекс 0.2 хувиар дээшилжээ. [ВГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН
МЭДЭЭ

**ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ
ЭНД БАЙРЛАЖ БОЛНО**

99903584, 99903581

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД						
НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	62.28	▲ +3.89%	1/11/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.02	▼ -9.09%	1/11/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	8.4	▲ +3.7%	1/11/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.033	▲ +3.13%	1/11/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	1/11/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.62	▼ -11.15%	1/11/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.7	▲ +7.8%	1/11/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.255	▼ -3.77%	1/11/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.2	▲ +5.26%	1/11/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.43	▼ -1.15%	1/11/2017

ТҮҮХИЙ ЭД					
НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1189.48	▲ +0.43%	1/11/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	983.1	▲ +0.03%	1/11/2017
МӨНГӨ	SJA	унци	16.865	▲ +0.1%	1/11/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	262	▲ +0.29%	1/11/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	78.6	▲ +0.42%	1/11/2017
WTI ТОС	CLA	баррель	50.94	▲ +0.24%	1/11/2017
БРЕНТ	COA	баррель	53.71	▲ +0.13%	1/11/2017
БЕНЗИН	XBA		155.74	▲ +0.69%	1/11/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.239	▼ -1.19%	1/11/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	334.75	▲ +0.51%	1/11/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	80.6	▼ -0.68%	1/11/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.204	▲ +0.29%	1/11/2017
БУДАА	RRA	центнер	9.65	▼ -0.26%	1/11/2017
БУУДАЙ	WA	бушель	425.25	▼ -0.35%	1/11/2017
КАКАО	CCA	тонн	2207	▲ +1.05%	1/11/2017
КОФЕ	KCA	фунт	1.477	▲ +2.43%	1/11/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ				
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
ГОВЬ ХК	GOV	10330	▲ 1.47%	1/11/2017
СҮҮ ХК	SUU	128.7	▼ -0.66%	1/11/2017
АДУУН ЧЛУУН ХК	ADL	1750	▲ 0.06%	1/11/2017
АТАР ӨРГӨӨ ХК	ATR	62000	◀▶ 0.00%	1/11/2017
БАГАНУУР ХК	BAN	2100	▲ 5.00%	1/11/2017
АРИГ ГАЛ ХК	EER	2300	◀▶ 0.00%	1/11/2017
ХӨХ ГАН ХК	HGN	65.99	▲ 7.30%	1/11/2017
ЖЕНКО ТҮР БҮРО ХК	JTB	67.9	▲ 13.15%	1/11/2017
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК	MDR	450.01	◀▶ 0.00%	1/11/2017
МАТЕРИАЛИМПЕКС ХК	MIE	8200	◀▶ 0.00%	1/11/2017
МЕРЕКС ХК	MRX	69	▲ 15.00%	1/11/2017
НАКО ТҮЛШ ХК	NKT	162	▲ 0.01%	1/11/2017
РЕМИКОН ХК	RMC	55.53	▲ 5.37%	1/11/2017
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	2679	▲ 2.53%	1/11/2017
УИД ХК	UID	549.01	▼ -10.73%	1/11/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД					
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5551.82	+20	▲ +0.36%	1/11/2017
DAX INDEX	DAX	11583.3	+19.31	▲ +0.17%	1/11/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15426.28	+37.33	▲ +0.24%	1/11/2017
S&P/ASX 200	AS51	5771.48	+10.78	▲ +0.19%	1/11/2017
S&P 500	INX	2268.9	+0.01	▼ 0.00%	1/11/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3152.829	-8.84	▼ -0.28%	1/11/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	19855.53	-31.85	▼ -0.16%	1/11/2017
TOP 20	MSETOP	12233.36	+24.99	▲ +0.2%	1/11/2017
FTSE 100	UKX	7275.47	+37.7	▲ +0.52%	1/11/2017
HANG SENG	HSI	22926.2	+181.35	▲ +0.8%	1/11/2017
NIKKEI 225	NKY	19364.67	+63.23	▲ +0.33%	1/11/2017



Mongolia
Forbes

**ШИНЭ ДУГААР ХУДАЛДААНД ГАРЛАА
ТҮГЭЭЛТИЙН БҮХ САЙН ЦЭГҮҮДЭЭР**

+976 77074646